

Ц.Пүрэв

ФСЭХ-ийн Социологийн секторийн эрхлэгч
Социологийн ухааны доктор (PhD)

Хөдөөгийн хүн амын нийгмийн зарим хэрэгцээг судалсан дүнгээс

Хүн амын эрэлт хэрэгцээг танин мэдэх явдал нь нийгмийн удирдлагыг оновчтой болгоход чухал ач холбогдолтой байдаг. Иймээс хөдөөгийн хүн амд шаардлагатай зарим материаллаг хэрэгцээг жагсаан бичиж тэдгээрийг ач холбогдлоор нь нэгээс эхлэн дугаарлахыг хариулагчдаас хүссэн юм. Оноосон тоон утгын дундажыг бодож үзэхэд хөдөөгийн өрх, хүн амын орлогыг нэмэгдүүлэх асуудал хамгийн нэгдүгээрт, дараа нь гэр сууцаа тохижуулах, гуравдугаарт эмчлүүлж сувилуулах хэрэгцээ оржээ¹.

Хүснэгт 1. Материаллаг хэрэгцээний үнэлгээ (дундаж утга)

Эрэлт хэрэгцээ	1986 он (малчин)	2002 он (малчин)	2002 он (нийт)
Гэр сууцаа тохижуулах	4.13	2.49	2.14
Орлогоо нэмэгдүүлэх	4.16	1.94	1.78
Эмчлүүлж сувилуулах	4.28	3.34	3.24
Удаан эдэлгээтэй соёлын бараа авах	6.57	5.09	5.23
Амины аж ахуйгаа өргөжүүлэх	4.73	3.64	3.84
Хадгаламжтай болох, арвижуулах	5.90	5.35	5.05
Гэрийн ажлаа хөнгөвчлөх	6.03	6.49	6.27
Хувцас авах	5.40	6.58	6.35
Хүнсний хангамжаа дээшлүүлэх	5.11	6.92	6.83
Чөлөөт цагийн ашиглалтыг сайжруулах	8.39	8.73	8.46

Хөдөөгийн өрхийн мөнгөн орлогыг нэмэгдүүлэх сууцны нөхцлийг сайжруулахын зэрэгцээ тэдний эрүүл мэндийг хамгаалах, эрүүлжүүлэх асуудал тоталитар дэглэм ноёрхож байсан 1986 онд нэн шаардлагатай байсан бол ардчилсан нийгэм байгуулахыг зорьж буй өнөө үед ч тулгамдсан асуудал хэвээрээ байна. "Өсвөр үеийнхний хэрэгцээ" сэдэвт судалгаанд хамрагдсан аймгийн төв, нийслэлд оршин суугч өсвөр үеийнхний 33.1-35.7 хувь нь эрүүл мэндийн тусламж үйлчилгээ өнөөгийн бидний хэрэгцээ шаардлагыг хангаж чадахгүй байна гэж хариулсан бол хөдөөд энэ үзүүлэлт 41.8 хувьтай байсан юм. Түүнчлэн манай судалгаанд оролцсон хөдөөгийнхний 63 хувь нь эрүүл мэндээ дунд буюу түүнээс доош үнэлснийг бодолцвол эмчлүүлж сувилуулах хэрэгцээ их байгааг ойлгоход төвөггүй. Гэтэл эрүүл мэндийн яамны судалгаагаар сумдын хүн эмнэлгийн зөвхөн 36% нь тэдний боловсруулсан стандартад тэнцэж байгаа юм.

Харьцуулсан судалгаагаар өнөө үед хөдөөд удаан эдэлгээтэй соёл ахуйн бараа авах, хадгаламжтай болох хэрэгцээ хуучнаас илүү чухалчлагдах болж, хувцас авах, хүнсний хангамжаа дээшлүүлэх хэрэгцээ буурах төлөв ажиглагдаж байгааг хэрэглээ, хэрэгцээний шинжид гарч байгаа бас нэг өөрчлөлт гэж хэлж болно. Хүний амьдрал ямар байх нь тэрээр ирээдүйдээ хэрхэн итгэлтэй, хэр зэрэг өөдрөг үзэл бодолтой байгаагаас багагүй шалтгаалдаг. Хөдөөгийнхөн ирээдүйн амьдралаа дараах байдлаар төсөөлөн бодож байна.

¹ Энэ өгүүлэлд "Хөдөөгийн хүн амын амьдралын хэв маяг" (1986, 2002 он), "Өсвөр үеийнхний хэрэгцээ" (2000 он) зэрэг судалгааны дүнг ашиглав.

Хүснэгт 2. Ирээдүйн амьдралын талаархи төсөөлөл

№	Хувилбарууд	Хувь
1	Миний амьдрал өмнөхөөсөө сайжрана гэдэгт итгэлтэй байна	31.1%
2	Би ямар ч байсан боломжийн амьдраад байж чадна гэж үздэг	45.2%
3	Би цааш яаж амьдрах аргаа олохгүй л явна	14.2%
4	Амьдрал маань улам дордоно гэж санаа зовж байна	9.0%
5	Ийм нөхцөлд над шиг хүн яагаад ч амьдарч чадахгүй гэж үздэг	0.5%

Судалгаанд хамрагдагсдын дөрөвний гурав нь ирээдүйн амьдралаа гэрэл гэгээтэй, сайн сайхнаар төсөөлөн бодож, өөдрөг үзэл бодол, итгэл үнэмшилтэй байгааг хөдөөд явуулсан нийгэм эдийн засгийн шинэчлэлийн бодит дүн гэж үзвэл таван хүн тутмын нэг нь сэтгэл зүйн хувьд дарамттай, ирээдүйдээ итгэл муутай гутрангуй үзэлтэй байгааг шинэчлэлийн үйл явцад дасан зохицож чадахгүй байгаагийн илрэл хэмээн үзэж болох юм. Түүнээс гадна хөдөөгийн хүн амын дотор өөдрөг үзэлтэн олон байгааг хөдөөгийн хүн ам ялангуяа нүүдэлчдийн “амны билгээс ашдын билиг” гэсэн уламжлалт сэтгэлгээтэй холбон тайлбарлаж болно.

Ирээдүйн амьдралын талаархи хүмүүсийн бодол төсөөлөл нийгэм мэргэжил, нийгэм-хүн ам зүйн шинжээр ялгаатай байв.

Хүснэгт 3. Ирээдүйн амьдралын талаархи төсөөлөл (ажил мэргэжлийн бүлгээр)

Төсөөлөл	Малчин	Бизнесмен	Ажилчин	Төрийн захиргаа үйлчилгээний сэхээтэн	Тэтгэвэрт	Ажилгүй
Өөдрөг	78.5	86.4	73.4	77.4	82.8	64.1
Гутрангуй	21.5	13.6	26.6	22.6	17.2	35.9
Бүгд	100%	100%	100%	100%	100%	100%

Ажилгүйчүүдийн дотор өнөөгийн амьдралдаа сэтгэл дундуур байхад бизнес эрхлэгчид түүнчлэн тэтгэврийнхний дунд ийм хүмүүс харьцангуй бага байна. Эрэгтэйчүүдийн 83.4% нь ирээдүйдээ итгэлтэй байхад эмэгтэйчүүдийн хувьд энэ үзүүлэлт мэдэгдэхүйц доогуур буюу 70.9 хувьтай байгаа юм.

Түүнчлэн амьдралын нөхцөлдөө илүү сэтгэл ханамжтай хүмүүс ирээдүйн амьдралаа илүү өөдрөгөөр төсөөлж байгааг төвөггүй мэдэж болно. Тухайлбал амьдралын нөхцөлдөө сэтгэл ханамжтай хүмүүсийн 97.4 хувь нь ирээдүйгээ өөдрөг төсөөлж байхад сэтгэл ханамжгүй хүмүүсийн 63.3 хувь нь ийм итгэл үнэмшилтэй байлаа.

Хүснэгт 4. Амьдралын нөхцлийн ханамж, ирээдүйн амьдралын төсөөлөл

Ирээдүйн амьдралын төсөөлөл			
Амьдралын нөхцөл	Өөдрөг	Гутрангуй	Бүгд
Сэтгэл ханамжтай	97.4	2.6	100.0
Дунд зэрэг	74.4	25.6	100.0
Сэтгэл ханамжгүй	63.3	37.6	100.0

Хөдөөгийн хүн амын ажил амьдралыг судлахын тулд хөдөөгийнхний амьдралын төлөвлөгөө ажил амьдралын зорилго, түүнийгээ хэрэгжүүлэх арга замын талаархи үзэл бодлыг танин мэдэх шаардлагатай.

Хөдөөд мөнгөн орлого нь хүрэлцээ муутай айл өрх олон байгаагаас тэдний 80 хувь нь мөнгөн орлогоо нэмэгдүүлэх зорилго тавьж, найман өрх айл дутмын гурав нь энэ зорилгоо хэрэгжүүлэх боломжтой гэж үзжээ. Судлагдагсдын ихэнх нь (55.2%) ямар нэгэн мэргэжил эзэмшихээр төлөвлөсөн ч тэдний бараг гуравны хоёр нь биелэнэ гэдэгтээ итгэл муутай, хэрэгжүүлэх арга зам нь бүрхэг байна. Түүнчлэн

хоршоо пүүс байгуулах, өөр байгууллагад шилжин ажиллах, ажлаа өөрчлөх хүсэлтэй хүмүүс ч нилээд байгаа юм. Шилжин суух газрын талаар тэдний саналыг үзвэл ойрын ирээдүйд төв суурин газар бараадах сонирхолтой хүмүүсийн тоо огцом нэмэгдэх төлөвтэй байна.

Хүснэгт 5. Амьдралын төлөвлөгөө (ойрын таван жилд)

Зорилго	Зорилго тавьсан биелэхэд хэцүү	Зорилго тавьсан биелэнэ
Мэргэжил эзэмших	36.1	19.1
Өөр байгууллагад шилжих	21.8	6.7
Хоршоо пүүс байгуулах	25.5	7.4
Удирдах ажил хийх	13.3	5.0
Орлогоо нэмэгдүүлэх	49.7	34.1
Сум суурингийн төвд байх	12.9	27.0
Аймаг хотын төвд байх	22.6	15.9
Том хотод байх	35.3	15.4

Хөдөөд юмны үнэ (малаас бусад) харьцангуй өндөр, ажилгүйдэл ядуурал нэмэгдсэн, түүнчлэн эрүүл мэнд, боловсрол нийгэм соёлын үйлчилгээ хоцронгуй, илүүдэл ажиллах хүчээ шингээх ажлын байр байхгүйгээс хөдөөнөөс төв суурин, нийслэл рүү чиглэсэн их нүүдэл улам бүр хүчээ авсаар байна. 1986 онтой харьцуулахад хөдөөнөөс төвлөрсөн суурин газарт оршин суухаар шийдсэн хүмүүсийн хувийн жин буюу боломжит урсгал хөдөлгөөн бараг 10 дахин нэмэгджээ.

Хүмүүсийн амьдралын төлөвлөгөө нийгэм хүн ам зүйн олон хүчин зүйлээс хамааран харилцан адилгүй байдаг. Ялангуяа эрхэлж буй ажил мэргэжил, нийгмийн эрхт байдал, амьдарч буй нутаг орны орчин нөхцөл, амьдралын хэв маяг түүнд хэрхэн нөлөөлдгийг судлаачид сонирхдог. Судалгаанд хамрагдсан хөдөөгийн оршин суугчид дотроос шилжих хөдөлгөөнд малчид хамгийн бага хамрагдах хүсэлтэй хэдий ч тэдний 23.1 хувь нь сум суурингийн төвд, 15 хувь нь аймаг хотын төвд ойрын таван жилд багтаж суурьшихаар бэлтгэж байгаа нь анхаарал татахгүй байхын аргагүй асуудал юм. Тэгвэл ажилгүйчүүдийн 56.7 хувь нь бизнес, хувиараа аж ахуй эрхлэгчдийн 66.6 хувь, тэтгэврийнхний 40 хувь нь энэхүү урсгал хөдөлгөөнд хамрагдахаар шийджээ. Харин ажилгүй хүмүүсийн ихэнх нь нийслэлд ирэх боломжтой гэж үзэж байна. Мэргэжлийн хувьд албан хаагчид, хүйсийн хувьд эмэгтэйчүүд шинээр мэргэжил эзэмших боломжоор илүү харин малчдын хувьд боломж хамгийн бага байдаг аж.

Бизнес эрхлэгчдийн 52 хувь, тэтгэврийнхний 42 хувь нь ойрын таван жилд орлогоо нэмэгдүүлж чадна гэж үзсэн байна. Тэдэнд нөөц бололцоо, оюуны чадамж, зорилгодоо хүрэх арга хэрэглүүр хөдөөгийн нийгмийн бусад бүлгээс илүү байгаад эргэлзэх зүйлгүй. Бас 25 хүртэл насны залуучууд тэтгэврийн насныхны дотор шилжин суурьшихаар бэлтгэж буй хүмүүс насны бусад бүлгээс илүүтэйн дээр эмэгтэйчүүд харьцангуй олон байгаа юм. Иймээс хөдөөгийнхөн амьдрал ахуйгаа сайжруулах орлогоо нэмэгдүүлэх нэг чухал арга зам бол аймаг хотын төвд шилжин суурьшиж ямар нэг ажил эрхлэх явдал гэж үзэж байгаа нь илэрхий. Гэсэн хэдий ч төвлөрсөн газарт ирээд таарч тохирох ажил олдохгүй санасан хүссэндээ хүрч амьдарч чадахгүй байгаа хүмүүс олон бий.

Хүмүүс амьдралын зорилго, түүнийгээ хэрэгжүүлэх арга замыг хэрхэн төсөөлөх нь тэдний боловсрол соёлын түвшин, идэвхи чармайлт, амьдралын туршлагаас хамаараад зогсохгүй монголын нийгмийн байгууллын шинэ төсөв, институтын зорилго чиг үүрэг, нийгмийн бүлгийн хэрэгцээ сонирхол нийгмийн хяналтын тогтолцоо хэрхэн төлөвшсөнөөс бас хамаарна. Зах зээлийн ардчилсан нийгэмд шилжиж буй өнөө үед Монголын хөдөөгийн хүн амын хүсэл тэмүүлэл, эрэлт хэрэгцээ ялангуяа үзэл бодол, итгэл үнэмшилд гарч буй өөрчлөлт, хандлагыг

зөв тодорхойлох нь тэдний хөгжлийг хангах нэг чухал нөхцөл болно. Учир нь хүний эрхэмлэн дээдэлдэг зүйлс, аливаа асуудалд хандах суурь хандлагаас гаргах шийдвэр, гүйцэтгэх үйлдэл нь ихээхэн шалтгаалдаг. Хөдөөгийн хүн амын зонхилох хэсэг болох өсвөр үеийнхний хүсэл мөрөөдөл итгэл үнэмшил үнэт зүйлсийн тогтолцоог тэдний амьдралын зорилго болон зарим үзэгдэл үйл явцад хандах тогтсон хандлага зэргээр тодорхойлох зорилго тавив.

Үнэт зүйлс нь нийгмийн бүлэг, нийгмийн үйл ажиллагаа, хүний үйлдэл зан төлөвийг зохицуулах үүрэг гүйцэтгэх бөгөөд түүн дээр тулгуурлан нийгмийн хэм хэмжээ хүний үйлдэл, зан төлөв, дүрэм журмууд төлөвшин бий болно. Түүгээр зогсохгүй хүний бүх үйлдлийн сэдэл шалтгаан нь тэрхүү үнэт зүйлсээс шалтгаална. Үнэт зүйлс гэдэг нь хүний эрхэмлэн дээдэлдэг зүйл болохын хувьд нэгдүгээрт хүний амьдралын зорилго арга хэрэглүүр хоёрдугаарт тухайн хүнд юмуу эсвэл нийгмийн тодорхой бүлэгт гарцаагүй хэрэгтэй гуравдугаарт итгэл үнэмшил болсон байх ёстой.

Үнэт зүйлсийн тогтолцоог судлах зүйлийн агуулгаар эдийн засаг, нийгэм, улс төр, ёс суртахууны гэх мэт, бие хүний амьдралд гүйцэтгэх үүргээр нь зорилго ба арга хэрэглүүр болох үнэт зүйлс, нийгмийн чиг үүргээр нь нэгтгэх ба задлах үнэт зүйлс гэх мэтээр ангилан үзэж болно. Судалгаанд хамрагдсан хөдөөгийн өсвөр үеийнхний үнэлэмж баримжаалал, эрэлт хэрэгцээний тогтолцоо дараах байдалтай байна.

Хүснэгт 6

Гол хэрэглээ	Сум	Хөдөө
Чинээлэг амьдрал	45.3	43.7
Боловсрол	44.9	31.7
Эрүүл мэнд	26.6	23.0
Аз жаргал	30.8	19.7
Ажил хөдөлмөр	14.5	13.1

Өсвөр үеийнхний үнэт зүйлсийн тогтолцооны онцлогийг гаргах зорилгоор судалгаанд оролцогсдоос *“Хэрэв чамд аз тохиож алтан загас баригдаад гурван хүслийг чинь биелүүлье”* гэвэл чи юу хүсэх вэ гэсэн асуултыг тавьсан юм. Өсвөр үеийнхний тавь гаруй янзын хариултын хувилбар сонгосноос үзвэл тэдний эрэлт хэрэгцээ сонирхол баялаг агуулгатай маш өргөн хүрээтэй болох нь харагдав. Хариултаас хамгийн их давтамжтайг ялгаж үзвэл хөдөөгийн өсвөр үеийнхэн боловсрол, чинээлэг амьдрал хоёрыг хамгийн чухал зүйлд тооцсон байна. Дараа нь аз жаргал, эрүүл мэнд, ажил хөдөлмөр зэрэг үнэт зүйлс түгээмэл тохиолджээ.

Хот хөдөөгийн өсвөр үеийнхний үнэт зүйлсийн тогтолцоонд адил төстэй тал байгаа боловч зарим нэг ялгаа бас байв. Үүнд олон хүүхэд залуучууд боловсролыг дээдлэж байгаа нь юуны урьд *“дээд баян эрдэм ном”* хэмээх нүүдлийн соёл иргэншлийн нийгмийн үнэт зүйлстэй давхцаж байна. Түүний зэрэгцээ нийгмийн шинэчлэлийн үед өсвөр үеийнхний дунд шинээр бий болж буй амьдралын стратеги болох үнэт зүйлс нь баяжих, чинээлэг амьдрах хүсэл эрмэлзэл юм. Судлагдагсдын арван хүн тутмын дөрөв нь баян болох хүсэлтийг (алтан загасанд) тавьжээ. Энэ нь хүнийг дээд үнэт зүйлс хэмээн үзэж, түүний хэрэгцээг хангах чинээлэг амьдралыг гол зорилгоо болгодог өрнийн иргэншлийн үнэт зүйлс давамгайлах хандлага илэрч *“Доод баян эд хөрөнгө хэмээн үздэг Монгол уламжлал буй”* гэрч гэлтэй.

Бие хүний үнэлэмж баримжааллыг стратегийн үндсэн хэв маягуудаар нь элбэг дэлбэг байдлын, амжилтын, өөрийгөө илэрхийлэх хэмээн нөгөө талаар ангилсан байдаг. Уламжлалт хийгээд хямралт нийгэмд үйлдвэрлэл үйлчилгээ саатсанаас элбэг дэлбэг амьдралыг эрхэмлэгч олон байдаг нь бас зүй тогтолт үзэгдэл юм.

Тэгвэл боловсрол эзэмших, эрүүл мэнд байх эрмэлзэл нь амжилт олох нэгэн чухал хэрэглүүр болно.

Өөрийгөө илэрхийлэх гэсэн эрмэлзэлд хурдан өсч том болох, ухаантай, царайлаг, хүч чадалтай хүн байх, авъяас чадвараа хөгжүүлж гадаад хэл сурах, гадаад оронд аялалаар явах, алдартай жүжигчин эсвэл спортын од болох хэрэгцээг оруулж болох юм. Ингэж ангилбал сумын төвийн 28 хувь, хөдөөгийн өсвөр үеийнхний 12 хувь нь өөрийгөө илэрхийлэх хэрэгцээтэй байжээ. (Өсвөр үеийнхний хэрэгцээг судалсан судалгааны тайлан. УБ., 2000.53 дахь тал)

Ийнхүү өсвөр үеийнхний үнэлэмж баримжаалалд элбэг дэлбэг байдлын болон амжилт олох хэрэглүүр болох үнэт зүйлс давамгайлахын хамт өөрийгөө илэрхийлэх хүсэл эрмэлзлэл буй болж байна.

Хүүхэд залуучууд нийгмийн эрхт байдал, нэр хүндэд нөлөөлдөг хүчин зүйлсийн талаар ямар үзэл бодол тогтсон хандлагатай байгааг сонирхсон юм.

Хүснэгт 7. Чиний бодлоор хүүхэд залуучуудын нийгэмд эзлэх байр суурь тэдний нэр хүнд нь ямар хүчин зүйлсээс хамаардаг вэ?

	Бүгд	Сум	Хөдөө
Эцэг эхийн нийгмийн байдал эрх мэдэл албан тушаалаас	40.5	37.5	38.4
Өөрийн боловсрол мэдлэгийн түвшингээс	49.9	47.7	42.6
Амьдралын туршлагаас	14.2	15.4	13.4
Авъяас чадвараас	44.8	46.0	32.1
Ангидаа эсвэл хамт олны дунд эзлэх байр суурь, эрх мэдлээс	12.9	12.3	10.5
Танил тал найз нөхдөөс	12.1	13.0	13.7
Идэвхи чармайлтаас	24.4	25.6	16.38
Үзэл бодол, улс төрийн байр сууриас	8.3	7.6	6.8
Ёс суртахууны байдал, соёлын түвшингээс	12.6	8.2	15.3
Хөрөнгө чинээ, бэл бэлчингээс	13.8	13.1	17.9
Өөрийгөө илэрхийлэх чадвараас	16.0	11.7	14.7
Бусад			

Хүснэгтээс хүүхэд залуучуудын нийгэмд эзлэх байр суурь нэр хүндэд хувь хүний хүчин зүйлүүд түүний дотроос боловсрол мэдлэгийн түвшин, авъяас чадвар, идэвхи чармайлт шийдвэрлэх нөлөөтэй гэж тэд үзэж байна. Түүний сацуугаар танил тал найз нөхөр, хөрөнгө чинээ бэл бэнчин, ялангуяа эцэг эхийн нийгмийн байдал, эрх мэдэл, албан тушаал, улс төрийн байр суурь зэрэг хувь хүнээс өөрөөс нь үл хамаарах хүчин зүйлүүд өсвөр үеийнхний нийгэмд эзлэх байр суурь нэр хүндийг тодорхойлоход чухал үүрэгтэй байдаг гэсэн үзэл бодол, тогтсон хандлага бүхий өсвөр үеийнхэн цөөнгүй байгааг судалгааны дүн харуулав. Энэ бүхэн нь Монголын хөдөөгийн нийгмийн амьдралд бодитой оршиж байгаа үзэгдэл, үйл явцын тусгал болох нь мэдээж. Хөдөөгийн хүн амын эрэлт хэрэгцээ, амьдралын төсөөлөл, зорилго, төлөвлөгөө үзэл бодол тогтсон хандлагын онцлог, ялгаатай байдлыг танин мэдэж түүнд нөлөөлснөөр нийгмийн удирдлагыг боловсронгуй болгох, улмаар хүний үйлдэл, зан төлөвийг залж зохицуулах бололцоо бүрэлдэнэ.

Судалгаанд оролцогчид хөдөөгийн нийгмийн хөгжлийг түргэтгэх, удирдлага зохион байгуулалт, хүмүүсийн ажил амьдралын орчин нөхцлийг сайжруулах чиглэлээр олон санал гаргасан нь хөдөөгийн нийгмийн бодлогыг боловсронгуй болгоход чухал ач холбогдолтой.

Юуны урьд хөдөө орон нутгийг хөгжүүлэх, цахилгаан эрчим хүчээр хангах, зам тавих, орон сууц барих, соёл боловсрол, эмнэлэг ахуйн үйлчилгээг сайжруулах, албан бус сургалтын тогтолцоог хөгжүүлэх асуудал хамгийн чухал болохыг уулзаж ярилцсан арван хүн тутмын дөрөв нь санал болгож байв.

Түүнчлэн хөдөөгийнхнийг амьдрах ухаанд сургах, зах зээлийн сэтгэлгээтэй болгох ажил хоцрогдож байгааг дурджээ. Дээрхи сэдэвтэй холбогдуулан зарим хүмүүсийн гаргасан санал, бодлыг дурдъя.

Үүнд:

- Сумыг цахилгаан гэрэлтэй болгохгүй бол соёл боловсролын болон бусад 24 цагийн арга хэмжээ үйлчилгээ явуулах боломжгүй, боловсон хүчин ч тогтохгүй байна.
- Нэн тэргүүнд хөдөөгийн малчин өрхийг холбоожуулах хөдөөгийн эмэгтэйчүүдийг эмнэлгийн үйлчилгээнд байнга хамруулах, ер нь малчдын эрүүл мэндэд гойд анхаарч, эмчлүүлэх тал дээр хангамж үзүүлэх шаардлагатай санагдана. Хөдөө орон нутагт дэд бүтэц хөгжөөгүй тул ирээдүйдээ итгэл муу байна. Энэ янзаараа байвал удахгүй говь нутаг эзэнгүйдэхэд хүрэх байх.
- Хөдөөгийн сэхээтнүүд боловсрол мэргэжлийн хувьд хоцрогддог, тэдэнд зориулсан сургалт, давтан сургалт үгүйлэгдэж байна. Хөдөөгийн малчид, залуучууд соёл боловсролоор дутагдаж оюуны хоосролд орлоо шүү. Ер нь хот хөдөөгийн боловсролын зааг ялгаа улам нэмэгдэж байна.
- Хоёрдугаарт үндэсний үйлдвэрлэлээ сэргээх, хөдөөд ажлын байр бий болгох, залуучуудыг ажилтай болгох нэн шаардлагатай гэж гуч орчим хувь нь хариулжээ.
- Үүнтэй уялдуулан малчид хөдөөгийн бизнес эрхлэгчдэд хөнгөлөлттэй болон хүүгүй зээл олгох асуудал ч хөндөгдсөн байв.
- Дотоодын үйлдвэрлэлийг сэргээж, ажлын байр бий болгон ялангуяа залуучуудыг ажлаар хангахгүй бол хөдөө орон нутгийнхан зэрлэгших хандлагатай байна гэжээ.

Гурав дахь анхаарал татсан асуудлын нэг нь хүмүүсийн амьдралын түвшинг дээшлүүлэх тухайлбал тэтгэвэр цалинг нэмэх, 24.4 хувь малчдыг малжуулах, малчин болон төрийн албан хаагчийн нийгмийн асуудлыг шийдвэрлэх, цалингийн сүлжээг хянан үзэх, мэргэжилтэнд говийн нэмэгдэл олгох нь зүйтэй гэж үзжээ.

Дөрөвдүгээрт хөдөөгийн ажил амьдралд илэрч буй доголдол дутагдлыг засах, сөрөг үзэгдэлтэй тэмцэх талаар олон хүн санал гаргажээ.

Үүнд: Хуулиа хэрэгжүүлж сахилга хариуцлагыг сайжруулах төрийн албыг ялангуяа доод шатанд чадваржуулах, сум багийн засаг дарга нарын ажлыг сайжруулах, хүнд суртлыг арилгах, хүүхэд залуучуудын хүмүүжилд анхаарах, архидалтыг багасгах, хулгайтай тэмцэх, намаар талцалгүй эв эетэй байх, асрамжийн хүүхдийг багасгаж эцэг эхийн хүлээх хариуцлагыг өндөржүүлэх, цөлжилтийн эсрэг тууштай тэмцэх явдал чухал болохыг онцлон тэмдэглэсэн байна.